# Mongolia's Statement

Mongolia became a pathfinding country in October of 2018. As part of the Together to #EndViolence Solutions Summit series, the Ministry of Labour and Social Protection has made commitments to end violence against children and issued the *Leaders Statement*.

Key highlights from the Leaders statement are as follows:

1. Strengthen and promote child safeguarding at all levels including preventing children from alcohol abuse, violence, school and cyber bullying.
2. Strengthening service delivery systems to develop family-centred services for children including programs for supporting families of children at-risk.
3. Strengthen legal environment and implementation of policies and regulations to reduce violence against children including adopting and implementing child protection policies.
4. Continue to provide Training and capacity building for family doctors and health workers. Introduce home visit and safe schooling programs outlined in the INSPIRE strategies.



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5, Утас: 26-15-53,
Факс: 32-86-34, Цахим шуудан: mlsp@mongolnet.mn
Цахим хуудас: www.mlsp.gov.mn

2022.05.06 № 01/1268

танай ______________-ны №______________-т

ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЛИЙГ
ТАСЛАН ЗОГСООХ ДЭЛХИЙН
ТҮНШЛЭЛД

Хүүхдийн эсрэг хүчирхийллийг
бууруулах чиглэлээр

Монгол Улсын Засгийн газар нь хүүхдийн эсрэг хүчирхийллийг урьдчилан сэргийлэх Дэлхийн түншлэлд нэгдэж, INSPIRE стратегийг хэрэгжүүлэгч орон болж сонгогдсоны хувьд эх орныхоо ирээдүй болсон хүүхдүүдийг аюулгүй, амар амгалан гэр бүл, хүүхдэд ээлтэй нийгмийн орчинд өсөж эрүүл энх, эрдэм мэдлэгтэй иргэн болгон төлөвшүүлэхийн тулд салбар бүрт хүүхэд хамгааллын бодлогыг дэмжин ажиллаж байна.

Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд манлайлал, хамтын ажиллагаа, салбар дундын зохицуулалтыг хангаан ажиллахын зэрэгцээ, гэр бүлд түшиглэсэн хүүхэд хамгааллын үйлчилгээг хөгжүүлэхэд чиглэсэн эрх зүйн болон үйлчилгээний шинэчлэлийг хийж байна.

Бид үйлчилгээг хүүхдэд ээлтэй болгох ажлын хүрээнд эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд түүний гэр бүлд дэмжлэг үзүүлэх, кейс менежментийн үйлчилгээ үзүүлэх чадавхыг сайжруулах, залуу гэр бүлийг ажил хөдөлмөрт холбон зуучлах, хөгжүүлэх, эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, гамшиг, онцгой байдлын үед хүүхэд хамгааллын бодлого стандартыг тодорхойлж, хүүхэд гэр бүлд хүрэх үйлчилгээний санхүүжилтийн нормативыг батлан хэрэгжүүлж байна.

Монгол улсын Засгийн Газраас хэрэгжүүлж байгаа eMongolia хөтөлбөртэй уялдуулан "Нийгмийн ажлын мэдээллийн сан","etuslamj" зэрэг програмыг хөгжүүлж статистик мэдээллийн чанарыг сайжруулахыг зорьж, хүүхэд хамгааллын үйлчилгээг цахимжуулж байна.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулахтай холбоотой бодлого, эрх зүйн зохицуулалт хийх аливаа хүчирхийлэл, хүний наймааны эрсдэлд хүүхэд өсвөр үеийнхэн өртөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг илрүүлэх ажилд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, хүүхэд хамгааллын бодлогыг батлан мөрдүүлэх, сурагчид сургууль дээрээ нийгэм-сэтгэл зүйн дэмжлэг авах, эрүүл мэндийн салбарын ажилтнууд хүүхдийн эсрэг хүчирхийллийг мэдээлэх, яаралтай хариу арга хэмжээ авахад эмч, эмнэлгийн ажилтнуудыг сургах, чадваржуулахын зэрэгцээ INSPIRE стратегид дурдагдсан гэрийн эргэлтийн хөтөлбөр, аюулгүй сургууль аргачлалыг анхан дунд шатны байгууллагаар дамжуулан хийнэ.

Цаашдаа нийгмийн бүхий л орчинд хүүхдийг хамгаалахад анхаарал хандуулж архидалт, хүчирхийлэл, сургуулийн болон цахим орчинд гарч байгаа дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, тэдний нийгмийн харилцааны болон амьдрах ур чадварын сургалтад хамруулж зорилтот бүлгийн хүүхдийг нийгэмшүүлэх зорилтот

153220665
D. 2022 on 05 sar A4

хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх замаар эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлыг хэрэгжүүлнэ.

Монгол Улсын Засгийн Газар хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох чиглэлээр манлайлах үүргээ биелүүлж, дэлхийн хэмжээнд та бүхэнтэй хамтын ажиллагааг үргэлжлүүлэн ажиллах болно.

А.АРИУНЗАЯА

D: 2022 on 05 sar A4

nofficial translation

TO THE GLOBAL PARTNERSHIP TO END VIOLENCE AGAINST CHILDREN

Re: Government of Mongolia actions to end violence against children

As a member to the Global Partnership to End Violence Against Children and one of the path finding countries of the INSPIRE Strategy, the Government of Mongolia is dedicated to promote child safeguarding at all levels of socio-ecological environment to guarantee a safe and peaceful family and child-friendly environment for children so that they grow up as healthy and educated members of the society.

Besides ensuring leadership and inter-sectoral coordination to prevent violence against children, our Ministry has been working to reform a legal environment and service delivery systems to develop family-centred services for children. We carry out the programs for supporting families of children at-risk; conduct capacity building trainings for effective case management; provide employment services for young families and income generating activities; and promote positive parenting. The National Standards on Child Protection in Emergencies and the Standard Operating Procedure on Financing Child Protection and Family Services have been approved.

The Government of Mongolia prioritizes a digital transition and implements an E-Mongolia program. In line with this, we are in a process of digitalizing child protection services and social workers' information database, and developing the "E-Assistance" software in order to improve quality of child protection services data.

Moreover, we take measures to implement policies and regulations to reduce violence against children; prevent children and adolescents from being exposed to the risks of violence and human trafficking; increase public involvement in reporting child maltreatment; adopt and implement child protection policies; and provide students with MHPSS at schools. We provide training and capacity building for family doctors and health workers so that they fulfil their obligations to mandatory Sreporting about violence against children and providing appropriate responses. We plan to introduce home visit programs and safe schooling programs outlined in the INSPIRE.

In the near future, we will focus on safeguarding children in all social environments, preventing them from alcohol abuse, violence, school and cyber bullying through advocacy and social and life skills training programs for target groups of children.

The Government of Mongolia is committed to continue its leading role in ending violence against children and is looking forward to strengthening our cooperation with the Global Partnership.

Sincerely,

ARIUNZAYA AYUSH

MINISTER FOR LABOUR AND SOCIAL PROTECTION